



Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын
үйл ажиллагааны тайлан

2016 он

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг
ОУЗСТ-ийн Ажлын алба

АГУУЛГА

Нэг. 2016 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тухай;

Хоёр. ОУИТБС-ын шаардлага бүрийг хангасан байдал, явц;

Гурав. Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм;

Дөрөв. Ажлын төлөвлөгөөний биелэлтийн байдал, биелсэн зорилтуудын ач холбогдол;

Тав. Цаашид хэрэгжүүлэх ажлын томьёолол, оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх тухай;

Зургаа. Монгол Улсад 2016 онд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд үүссэн бэрхшээл, хариу арга хэмжээ, авсан сургамж

Долоо. Тайланг боловсруулсан, баталсан огноо;

Найм. Хавсралтууд;

1. Монголын ОУИТБС-ын 2016 оны төлөвлөгөөний биелэлт
2. Монголын ОУИТБС-ын 2017 оны төлөвлөгөө
3. Монголын ОУИТБС-ын хүрээнд ашиг хүртэгч эздийг ил тод болгох 2020 он замын зураг
4. Монголын ОУИТБС-ын өгөгдлийн нээлттэй байдлын бодлого, журам.

НЭГ. 2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНГИЙН ТУХАЙ

1.1. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаануудын тойм

Үндэсний зөвлөл

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл 2016 оны 12 дугаар сарын 20- ны өдөр хуралдааныг Монгол Улсын Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга Ж.Эрдэнэбат удирдан явуулж дараах асуудлуудыг хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргасан .

Хэлэлцсэн нэгдүгээр асуудал Монгол Улсын Улаанбаатар аудит корпорац, Их Британийн Харт Нойрс ХХК-ийн хамтарсан концерцумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны буюу 10 дугаар нэгтгэл тайлан байсан бөгөөд гарсан шийдвэрүүдийг сийрүүлбэл:

1. Монгол Улсын Улаанбаатар аудит корпорац, Их Британийн Харт Нойрс ХХК-ийн хамтарсан концерцумын боловсруулсан Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны тайланг дэмжиж, хуралдаан дээр гишүүдийн саналыг тусган батлахаар тогтов.
2. Монгол Улсын 2015 оны тайланг оролцогч бүх талууд өөрсдийн цахим хуудаст байрлуулах, Ажлын албанаас хураангуй хувилбарыг нийтэд ил тод болгож, сурталчлах нь зүйтэй гэж үзэв.
3. Монгол Улсын 2015 оны тайлан, 2016 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2017 оны ажлын төлөвлөгөөтэй хамт ОУИТБС-ын олон улсын удирдах хороонд 2016 оны 12 дугаар сарын 31- ний дотор илгээхийг Ажлын албанд даалгав.
4. Энэхүү тайлан, Үндэсний зөвлөлийн хуралдааны талаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав.
5. Энэхүү тайлангаар заасан зөвлөмж бүрээр дараах шийдвэрүүдийг гаргав.:

Зөвлөмж 1 - Үндэсний зөвлөлөөс нь энэ асуудлыг Уул уурхайн сайдад даалгаж, АМГТГ нь БХГ-үүдийг олон нийтэд ил болгох нь зүйтэй.- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2017 оны эхний хагаст багтаан зөвлөмжийн дагуу шийдвэрлэхийг даалгав.

Зөвлөмж 2- АМГТГ нь олон нийтэд ил тод болгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл нь ОУИТБС-ын Стандартын хамгийн наад захын шаардлагыг хангасан байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. *(энэ зөвлөмжийг өмнө жил бас өгсөн байсан)*- Ашигт малтмал газрын тосны газарт 2017 оны эхний хагаст багтаан зөвлөмжийн дагуу шийдвэрлэхийг даалгав.

Зөвлөмж 3- АМГТГ нь лицензийн талаарх тодруулж буй мэдээллээ зохистой эсэхийг нягталж үзэж, Ажлын хэсэг нь энэ асуудлын мөрөөр АМГТГ-т хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.- Ашигт малтмал газрын тосны газарт 2017 оны эхний хагаст багтаан зөвлөмжийн дагуу шийдвэрлэхийг даалгав.

Зөвлөмж 4- Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь БОАЖЯ- тай хамтран бүх олборлох үйлдвэрлэлийн ТӨААН-үүдийг нөхөн сэргээлтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулж, цаашдын санхүүгийн тайландаа нөхөн сэргээлтийн зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу тусгахыг зөвлөж байна.-

Эрдэнэс Монгол ХХК-д БОАЖЯ- тай хамтран 2017 оны эхний хагаст багтаан шийдвэрлэхийг даалгав.

Зөвлөмж 5- Ажлын хэсэг нь аудитын тайланд өгсөн хязгаарлалтын талаар Сангийн яам болон ТӨААН-үүдтэй зөвшилцөж, санхүүгийн хяналтанд шаардлагатай сайжруулалтыг авч хэрэгжүүлэх төлөвлөгөө цаг хугацаа, боломж нөөц байгаа эсэхийг баталгаажуулахыг зөвлөж байна.-Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, 2017 оны эхний хагаст багтаан шийдвэрлэхийг Ажлын албанд даалгав.

Зөвлөмж 6- ОУИТБС-ын Засгийн газрын тайлагналын баталгаажуулалтыг сайжруулахын тулд Ажлын хэсэг нь МҮАГ-тай хамтран ажиллахыг зөвлөж байна. ҮАГ-ын ажлын төлөвлөгөөнд энэ ажлыг тусгуулсанаар ЗГ-ын ОУИТБС-д ирүүлсэн мэдээнд дүгнэлт өгөхөд шаардлагатай нөөц бололцоо болон цаг хугацаа бүрэлдэнэ. Дараагийн тайланд энэхүү асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд ҮАГ-ын 2017 оны ажлын төлөвлөгөө батлагдах гэж байгаа энэ үед нэн даруй ҮАГ-тай зөвшилцөх шаардлагатай. -2018 оноос эхлэн үйл ажиллагааны төсөвтөө зардал хуваарилуулан, мөрдөж ажиллахыг Үндэсний аудитын газарт зөвлөмж болгов.

Зөвлөмж 7- Эдгээр баталгаажуулалтын асуудлуудын нийцлийн түвшин чухал учир сайжруулах шаардлагатай. ОУИТБС-ын Ажлын алба нь дараагийн ОУИТБС-ын тайланд илүү сайн нийцлийг бий болгохын тулд компаниуд, ТӨААН болон Засгийн газрын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.-Холбогдох талуудтай хамтран ажиллаж, 2017 оны эхний хагаст багтаан эргэн мэдээлэхийг Ажлын албанд даалгав.

Зөвлөмж 8 - ОУИТБС-ын Ажлын алба нь дараагийн ОУИТБС-ын тайлангийн нийцлийг сайжруулах үүднээс компаниуд, ТӨААН болон Засгийн газартай хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Ажлын хэсэг нь үл нийцэх асуудал гарвал зөвшөөрөл авах механизмыг харгалзан үзэх шаардлагатай. Холбогдох талуудтай хамтран ажиллаж, 2017 оны эхний хагаст багтаан эргэн мэдээлэхийг Ажлын албанд даалгав.

Зөвлөмж 9- ОУИТБС-ийн ОТАХ нь ОУИТБС-ын тайлан бүрийн өмнө цахим тайлагналын системийг ашиглан тухайн компаниудыг олборлох үйлдвэрлэлийн компани мөн эсэхийг урьдчилан шалгаж байхыг зөвлөж байна -2016 оны нэгтгэл тайлангийн 2017 оны эхний хагаст багтаан эргэн мэдээлэхийг Ажлын албанд даалгав.

Зөвлөмж: 10- МОУИТБС-ийн цахим тайлангийн системийг гүйцэтгэгчээс бүрэн хүлээн авахдаа сонгон шалгаруулалтын материалд заагдсан шаардлагын дагуу дараах байдлаар хүлээн авах. Үүнд:

- Системийг нөөц хувилбартайгаар хүлээн авах
- Системийн хэвийн ажиллагаанд шаардлагатай гарын авлагуудыг хүлээн авах (тухайлбал: Үйлдлийн систем суулгах, түүнд шаардлагатай аюулгүй байдлын тохиргоонуудыг хийх, нөөц хувилбарын тохируулах, өгөгдлийн санг суурилуулах гарын авлага)
- Системд цаашдын хөгжүүлэлтэд шаардлагатай эх кодыг авах
- Системийг дотроос болон гаднаас penetration test болон stress test хийлгэн хүлээн авах

Цахим системийн аюулгүй байдлын хувьд

- Системийг SSL сертификат бүхий хандалттай болгох
 - Цахим тайлангийн системийн үйлдлийн системийн шинэчлэлийг (update) байнга хийх
 - Системд зөвхөн админ эрх бүхий хэрэглэгчийн хандах ip хаяг болон ямар портоор хандалтыг тохируулах ба бусад шаардлагагүй портыг хаах
 - Цахим тайлангийн системийн хандалтын болон халдлагын шинжтэй мэдээллийг илрүүлэх болон таслан зогсоох системд хамруулах
- Системийн үйл ажиллагааны зохистой байдлыг сайжруулах талаар
- Цахим тайлангийн системд хандах хэрэглэгчдийн эрх, үүргийг нарийвчлах журамд тусгах
 - Цахим тайлангийн системийг байрлуулах компанитай байгуулах гэрээнд тус системд зайлшгүй байх шаардлагатай аюулгүй байдал, нөөц хувилбар, өгөгдлийн санг хуулбарлах хамгаалах, ачааллыг хуваарилах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах талаар нарийн тусгах- Эдгээр зөвлөмжүүдийг судлан үзэж 2017 оны эхний хагаст багтаан эргэн мэдээлэхийг Ажлын албанд даалгав.

Зөвлөмж 11 - Хараат бус нэгтгэгч нь тайлангийн бэлтгэлд орох орцыг ирүүлэхийн тулд аль болох эрт сонгогдож, үйл явцад хамрагдах ёстой. Хараат бус нэгтгэгч нь цахим тайлагналын системийн агуулгын талаар шийдвэр гаргахаас өмнө 1 сарын сүүлээр хамруулах ёстой. –Ажлын албанд даалгав.

6. Хуралдаан дээр гишүүдээс гаргасан саналын дагуу:
- a. Бүх төрийн өмчийн компаниудад ОУИТБС-ын тайландаа тухайн жилийн санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг хавсаргах, нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэхийг үүрэг болгов.
 - b. Тусгай зөвшөөрөл, төсөл бүрээр тайлагнах боломжийг нэмэгдүүлэх үүднээс тусгай зөвшөөрөл бүрээр “зардлыгхаших”¹ боломжийг судалж, 2017 оны эхний хагаст эргэж мэдээлэхийг АМГТГ-д даалгав.
 - c. Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн орлого буцаан олголтыг мэдээллийг сүүлийн 5 жил бүрээр гарггаж, Үндэсний зөвлөлд 2017 оны 1 дүгээр улиралд багтаан мэдээлэхийг БОАЖЯ-д даалгав.
 - d. 2015 оны тайлангаар гарсан зөвлөмжүүдийг дахин нягтлахыг Улаанбаатар аудит корпорацид санал болгов.
 - e. 2014-2015 оны тайлангуудаар гарсан бүх зөвлөмжүүдийг судлаж нэгдсэн зөвлөмж гаргаж хэлэлцүүлэхийг Ажлын албанд даалгав.
 - f. Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ISO MNS 26000:2012 стандартыг олон нийтэд таниулах ажлыг идэвхжүүлэх, холбогдох сургалтуудыг зохион байгуулахыг Ажлын албанд даалгав.

Хэлэлцсэн хоёрдугаар асуудал нь Монголын ОУИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тухай байсан бөгөөд дараах шийдвэрүүдийг гаргажээ.

1. Монголын ОУИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлттэй танилцав.
2. Хийгдээгүй ажлуудыг 2017 онд хэрэгжүүлж, явцыг Ажлын хэсэгт тухай бүр мэдээлж байхыг Ажлын албанд даалгав.

¹ Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн саналаар:

Хэлэлцсэн гуравдугаар асуудал нь Монголын ОУИТБС-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн тухай байсан бөгөөд Монголын ОУИТБС-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусган батлаж, төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэгт даалгахыг хамт Монгол Улсын ОУИТБС-ын гишүүний татвар, Дэд зөвлөлийн санхүүжилтыг БОАЖС-ын багцаас гаргах асуудлыг судалж, албан хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг Ажлын албанд даалгажээ. Дөрөвдүгээр асуудлаар Монголын ОУИТБС-ын өгөгдөлийн мэдээллийн нээлттэй байдлын журам, бодлогыг хэлэлцэж баталсан бол ОУИТБС-ын ашиг хүртэгч эздийг 2020 он гэхэд ил тод болгох замын зураг төлөвлөгөөний төслийн тухай тавдугаар асуудлыг баталж, хэвлэн нийтэлж, хэрэгжилтийг улирал бүр тайлагнахыг Ажлын албанд даалгав.

2017 оныг дэд зөвлөлийг чадавхжуулах болон ашиг хүртэгч эздийг ил болгох жил байхаар шийдвэрлэсэн байна.

Ажлын хэсэг

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий олон талт Ажлын хэсэг 2016 оны 4, 8, 11 дүгээр саруудад тус бүр 1 удаа, бүгд 3 удаа хуралдав. Хуралдаан бүрийн шийдвэрийг сийрүүлэв. Үүнд:

2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

1. Монгол Улсын ОУИТБС-ын хүрээнд олон улсын стандартын дагуу ашиг хүртэгч эздийг ил тод болгох дэд хэсгийг байгуулахаар тогтов. Хэсгийн удирдагчаар УУЯ-ны ЭЗСХО-ын хэлтсийн дарга Н.Энхбаярыг томилов.
2. Дэд хэсэгт орох төлөөллүүдийнхээ нэрсийг 5 дугаар сарын 1-ний дотор ирүүлэхийг даалгав.

2016 оны 8 дугаар сарын 4-ний өдөр

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

1. Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд ЕСБХБ-аас үзүүлж буй дэмжлэг, орон нутагт хэрэгжүүлэх харилцааны туршилтын төслийг хэлэлцэж батласан.²

2016 оны 11 дугаар сарын 18-ны өдөр

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

1. Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангийн төслийг дэмжиж, Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах
2. Монголын ОУ-ийн компаниудын ашиг хүртэгч эздийг ил болгох замын зураг хөтөлбөрийн дэмжиж, Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах
3. Монгол ОУИТБС-ын 2016 оны ажлын төлөвлөгөөний биелэлт, 2017 оны ажлын төлөвлөгөөний төслийг дэмжиж, Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах

1.2. Монголын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангийн тойм

Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэлийг хийж гүйцэтгэхээр Монгол Улсын Улаанбаатар аудит корпорац, Их Британ улсын Харт Нойрс компаниудын консерцум

² Иргэний нийгмийн төлөөллийн зарим гишүүд энэ хурлыг хурал биш гэж үзэж байгаа.

шалгарч, гэрээт ажлаа 2016 оны 7 дугаар сарын эхээр эхлүүлсэн. Энэ нэгтгэлд 202 компанийн төлбөр, тэднээс Засгийн газрын хүлээн авсан орлогын аудитын нэгтгэлийг явуулж, 8 дугаар сарын эхлэлийн семинарыг зохион байгуулж, 9 дүгээр сард эхлэлийн тайланг гаргаж, 12 дугаар сарын эхээр дуусгаж, төслийг Ажлын хэсгээр 11 дүгээр сард танилцуулан, дэмжлэг авсны үндсэн дээр Үндэсний зөвлөл 2016 оны 12 дугаар сарын 20- ны өдөр баталсан байна.

Ерөнхий хэсэг

2015 онд олборлох салбар нь Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний 16,7%, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 63,2%, экспортын 88%-ийг бүрдүүлсэн байна. 2016 оны эхний улирлын байдлаар бүх нутаг дэвсгэрийн 9,5 хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Одоогоор уул уурхайн салбарт 30 гаруй хууль, 40 орчим дүрэм заавар мөрдөгддөг байна. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 1866 компани, 3329 тусгай зөвшөөрөлтэй талбай дээр 57 төрлийн ашигт малтмалын хайгуул болон олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байна. Энэ тайланд ОУИТБС-ын стандартын дагуу Монголын ашигт малтмалын нөөц, нүүрс, зэс, төмөр, алт, хайлуур жонш, молибден, цайр, ураны нөөц болон стратегийн ордууд, бичил уурхай, нөхөн сэргээлт, тусгай зөвшөөрөл олголт, хайгуулын зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц, тусгай зөвшөөрөл олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлт, 2015 онд шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүд, бүртгэл, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геолог, хайгуулын ажлын тойм, хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын үйл ажиллагаа, үйлдвэрлэл, экспортын мэдээг оруулжээ. Мөн цаашлаад газрын тосны нөөц, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон байдал, байгуулагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн мэдээ зэрэг мэдээллийг оруулсан байна. Газрын тосны 19 компани буюу 25 бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж ажиллаж байв

2015 онд олборлох үйлдвэрлэлээс ЗГ-ын хүлээн авсан нийт орлого 1422,2 тэрбум төгрөг, үүнээс 544,6 тэрбум нь АМНАТ, 217,9 тэрбум нь ААНОАТ, 160,6 тэрбум нь газрын тосны орлого, 127,6 тэрбум нь НЭМДШ, 40 тэрбум нь хандив дэмжлэг байжээ. 2015 онд Монгол Улсын нийт 1,151,2 мянган хөдөлмөр эрхлэгчдийн 42,6 мянга нь уул уурхайн салбарт ажиллаж байгаа нь нийт ажиллагсдын 3,7% нь болж, 2014 оныхоос 1,7 мянгаар нэмэгджээ.

Энэхүү тайлангаар нэгтгэлд орсон компаниуд нь 126 нь ажиллагсдынхаа талаар мэдээлэл өгсөн байна. Нийт 22,0 мянган хүн ажилладаг гэж мэдүүлсний 1206 нь буюу 5,5 хувь нь гадаадын ажиллагсад байжээ.

2015 онд ОУИТБС-ын тайлан гаргах 1920 компаниас 747 компани цахимаар тайлангаа гаргасан нь 39 хувь болж өнгөрсөн жилээс 240 орчим компани буюу 30 гаруй хувиар буурсан байна. Тайлангаа гаргасан 747 компанийн төвлөрүүлсэн нийт орлогын дүн 1134 тэрбум төгрөг бол Засгийн газрын 1920 компаниас хүлээн авсан дүн 1422,2 тэрбум төгрөг байсан бөгөөд материаллаг босгыг шинэчлэн тогтоосноор 202 компаниудын тайланг нэгтгэсэн нь 1393 тэрбум төгрөг буюу 2015 оны орлогын урсгалын нийт 98 хувийг эзэлж байна. Нэгтгэлийн эцэст Засгийн газрын

тохируулагдсан дүн 1393 тэрбум, компаниудынх 1392 тэрбум төгрөг, болсноор цэвэр, тайлбарлагдаагүй зөрүү 112 сая төгрөг гэдгийг нотолсон байна.

Хандив дэмжлэг 2012 оны тайлангаар 13,1 тэрбум төгрөгөөр нотлогдсон бол 2013 онд 39,2 тэрбум төгрөг бараг 3 дахин өссөн бол харин 2014 онд 19 тэрбум төгрөг болж буурсан бол 2015 онд 40 гаруй тэрбум төгрөг эргээд нэмэгдсэн байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн тухай судалгаа хийхэд, ийм төрлийн байгууллага 16 байх бөгөөд 7 буюу Эрдэнэс Монгол, Шивээ-овоо, Багануур, Эрдэнэс Таван толгой, Эрдэнэ үйлдвэр, Монголпроцветмет, Дарханы төмөрлөгийн үйлдвэр нэгтгэлд хамрагдсан байна. Харин орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 4 байна. Таван Толгой, Могойн гол, Баянтээг компаниуд орон нутгийг төлөөлж, нэгтгэлд хамрагджээ.

Бенефициарь өмчлөлийн судалгааг явуулахад 2013 онд 215 компани, 2014 онд 30 компани, 2015 онд 51 компани энэ тухай мэдээллээ ирүүлсэн байна.

Компаниудын оролцоо

Нэгтгэлд компаниудын оролцоо өмнөх жилүүдээс сайн байсан хэдий ч зарим компаниуд хариу өгөлгүй ажлыг саатуулсан байна. Тайлагнаагүй 8 компаниудын нэрийг хавсаргасан байна.

Засгийн газрын байгууллагуудын оролцоо

Засгийн газрын байгууллагуудын оролцоо ерөнхийдөө хангалттай түвшинд байжээ. Мон-Атом ТӨК- ийн оролцоо хангалтгүй байсныг онцолсон байна.

1.3 Монголын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлан гаргах аудитын консерцумыг сонгон шалгаруулсан нь

Монголын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлан гаргах аудитын консерцум шалгаруулах удирдамжийг 2016 оны 1 дүгээр сарын сүүлчээр Засгийн газрын хэрэг эрхлэх газраас батлуулж, Үнэлгээний хороог байгуулсан байна. Үнэлгээний хорооны удирдамжийг боловсруулж, Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүдээс саналыг нь цахимаар авч, холбогдох нэмэлт өөрчлөлтийг ОУИТБС-ын 2013 оны шинэ стандартын шаардлагуудтай хамт оруулсан байна.

Сонгон шалгаруулалтыг 2016 оны 2 дугаар сараас эхлэн явуулж, 6 дугаар сарын эцсээр дуусгаж, Монгол, Их Британи улсын Улаанбаатар аудит корпорац, Харт Нойрс компаниудын консерцум шалгарсан. Гэрээг 7 дугаар сарын эхээр эхлүүлж, 12 дугаар сард дуусгасан байна.

1.4 Компани болон Засгийн газрын ОУИТБС-ын 2015 оны тайлан гаргах ажлыг зохион байгуулсан нь

Компанид тайлан гаргахад нь туслах зорилгоор 3 удаа богино мэдээг түгээж, төвийн сонин, ажлын албаны цахим хуудас, АМГ-ын цахим хуудас болон самбар дээр нь тайлангаа гаргах тухай зар тавьж, мэдээлэл түгээсэн байна. Тайлан гаргасан, гаргаагүйгээр нь ангилж, сонин дээр мэдээлэл тавьсан байна.

Тайлан гаргах үүрэг хүлээсэн Засгийн газрын байгууллагуудад тайлангаа гаргах албан тоотыг цахим тайлагналд нэвтрэх нууц үгийн хамт илгээсэн байна.

1.5 ОУИТБС-ын тайлагнал

Тайланг гаргаж, нэгтгэл тайланд орж байгаа компаниудын тоо жил бүр нэмэгдэж, зөрүү жил бүр буурч байна. Гэвч тайлан гаргаж байгаа компаниудын тоо буурч байна.

Он	Тайлан гаргасан компани	Сангийн яамнаас гаргасан Засгийн газрын тайланд хамрагдсан компанийн тоо	Монгол Улсын нэгтгэл тайланд орсон компани	Тайлбарлагдаагүй зөрүү
2006	64	137	25	4 тэрбум төгрөг
2007	102	184	38	775 сая төгрөг
2008	115	184	46	425 сая төгрөг
2009	129	363	101	58 сая төгрөг
2010	274	477	150	360 мянган төгрөг
2011	301	518	200	75 сая төгрөг
2012	1529	1829	200	360 сая төгрөг
2013	1198	1617	250	36 сая төгрөг
2014	992	1573	236	581 сая төгрөг
2015	747	1920	202	112 сая төгрөг

1.6 Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны ажлын төлөвлөгөөний биелэлт

2016 онд нийт 53 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 34 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлтийн хувь 65 байна.

Үндэсний зөвлөл, 1 удаа, Ажлын хэсэг 3 удаа, дэд хэсэг 2 удаа хуралдсан байна. Нилээд ажлууд хэрэгжүүлж чадаагүй шалтгаан нь Дэлхийн банкны төслийн санхүүжилт, түүний гэрээ бэлтгэх ажил саатаж, 8 дугаар сарын 20-н хүртэл ямар ч санхүүжилтгүй байснаас төлөвлөсөн ажлууд хугацаандаа хэрэгжихгүй саатсан байна. Саатсан гол ажлууд орон нутгийн Дэд зөвлөлийг чадавхжуулахтай холбогдсон болон Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулах зэрэг байсан бөгөөд эдгээр ажлуудыг 2017 онд хэрэгжүүлэхээр хойшлуулж, төлөвлөгөөнд оруулсан байна. Хэрэгжсэн томоохон ажлуудыг дурдахад: Үүнд:

Перу улсын нийслэл Лима хотноо 2016 оны 2 дугаар сард зохиогдсон Олон улсын ээлжит бага хурлын үеэр Монгол Улс “Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлснийхээ” төлөө ОУИТБС-ын даргын нэрэмжит шагналыг хүртсэн байна. Монгол Улс хошой шагналтай улс болоод байна. Өмнө нь 2011 онд тайлангаас тайланд хамрах мэдээллээ сайжруулан тайлагнаж байгаагийн төлөө мөн шагналыг хүртэж байсан. Уг хуралд Уул уурхайн сайд Р.Жигжид тэргүүтэй төлөөлөгчид оролцож, ОУИТБС-ын үзэсгэлэн гаргаж, Перу, Колумб зэрэг улсуудтай шууд хамтран ажиллах асуудлыг ярилцсан.

Уул уурхайн ашиг хүртэгч эздийн ил тод байдлын судлах ажлыг зохион байгуулах өргөн бүрэлдэхүүнтэйгээр дэд хэсгийг УУЯ дээр зохион байгуулж, холбогдох уулзалтуудыг зохион байгуулсан. Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэнтэй

хамтран сургалт зохион байгуулж, Замын зураг хэмээх төлөвлөгөөг боловсруулан, Үндэсний зөвлөлөөр 12 дугаар сард батлуулав.

Цахим тайлангийн системийн 2 дугаар шатны ажлыг дуусган, дүнг олон нийтэд Уул Уурхайн яам болон хэвлэл мэдээллээр танилцуулж, гарын авлага, брошурыг хэвлэн оролцогч талуудад сургалт зохион байгууллаа.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хороон дээр байгуулагдсан “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төслийн ажлын хэсэг 3 удаа хуралдаж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн хэдий ч, 2012-2016 оны УИХ хэлэлцэж чадсангүй.

ГОУХАН, Монголын уул уурхай сэтгүүлтэй хамтран хойд болон баруун бүсийн олборлох салбарын ил тод байдлын тусгайлсан номыг бэлтгэж, хэвлэн нийтлүүлэв.

ОУИТБС-ын гэрээний ил тод байдлын цахим хуудсыг Нээлттэй нийгэм форум, УУЯ-тай хамтран зохион байгуулж, дуусгаад байна.

Монгол Улсын ОУИТБС-ын Олон улсын баталгаажуулалтын 2016 оны 7 дугаар сарын эхээр зохион байгуулж, холбогдох тайланг дүнг танилцуулж ирсэн бөгөөд 12 дугаар сард эцсийн дүнг ирүүлнэ.

Орон нутгийн харилцааны ажлыг сайжруулах зорилгоор ЕСБХБ-ны туршилтын төслийг боловсруулах, судалгааг холбогдох байгууллагаар эхлүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.

2016 оны сонгуулийн дүнгээр шинэчлэгдсэн аймгийн удирдлагуудын уулзалтыг Засаг даргын орлогч, уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэнүүдийн түвшинд зохион байгуулж, ОУИТБС-ын дэд зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

ХОЁР. ОУИТБС-ЫН ШААРДЛАГА БҮРИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ, ЯВЦ

2.1 2015 оны нэгтгэл тайлан ОУ-ын стандартын шаардлагыг хангасан эсэх ОУИТБС-ын стандартын шаардлагуудад Монгол Улсын ОУИТБС-ын нэгтгэл тайланг нийцүүлж, Улаанбаатар аудит корпорац, Харт Нойрс, Ажлын хэсэг, алба хамтран ажиллаж, уг тайлан, үр дүн нь хүлээн авахуйц, нийцсэн гэж үзэн Үндэсний зөвлөлөөс баталж, зарим үйл ажиллагааг сайжруулах үүднээс 2017 оны төлөвлөгөөнд нэмэлт ажил оруулж баталсан байна.

2.2 2016 онд Монгол Улсад ОУИТБС-ыг хир түвшинд хэрэгжүүлсэн тухай олон улсын, хөндлөнгийн үнэлгээ хийгдсэн бөгөөд уг үнэлгээний судалгаагаар Засгийн газрын оролцоо хангалттай байж чадаагүй тухай гол дүгнэлт зөвшөөрч, 2017 оны ажлын төлөвлөгөөнд үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх ажлыг оруулсан байна.

Монгол Улсын ОУИТБС-ын Баталгаажуулалт- Үнэлгээ 2016			
Ангилал	ОУИТБС-ын стандартын шаардлагууд	Дугаар	Хангалт-гүй/?
ОУИТБС-ын үйл ажиллагаа, оролцоо, хяналт	Засгийн газрын оролцоо	1,1	?
	Компанийн оролцоо	1,2	
	Иргэний нийгмийн оролцоо	1,3	
	Олон талт бүлгийн удирдлага, үйл ажиллагаа	1,4	?
	Ажлын төлөвлөгөө	1,5	
Тусгай зөвшөөрөл, гэрээнүүд	Эрх зүйн орчин	2,1	
	Тусгай зөвшөөрлийн олголт	2,2	?
	Тусгай зөвшөөрлийн бүртгэл	2,3	?
	Гэрээ хэлэлцээр, тэдгээрийг ил тод болгох бодлого	2,4	
	Бенефициарь өмчлөгч	2,5	
	Төрийн оролцоо, эзэмшил	2,6	??
Олборлолт, хяналт	Хайгуулын мэдээлэл	3,1	
	Олборлолтын мэдээлэл	3,2	
	Экспортын мэдээлэл	3,3	?
Орлого төвлөрүүлэх	Иж бүрэн байдал	4,1	
	Мөнгөн бус орлого	4,2	?
	Бартерын хэлцэл	4,3	
	Тээвэрлэлтийн орлого	4,4	
	Төрийн өмчит компаниудын шилжүүлэг	4,5	?
	Орон нутагт шууд төлдөг төлбөр	4,6	
	Задаргааны түвшин	4,7	
	Мэдээллийн цаг хугацаа	4,8	
	Мэдээллийн чанар	4,9	?
Орлогын хуваарилалт	Орлогын менежмент, хуваарлалт	5,1	
	Орон нутгийн шилжүүлэг	5,2	?
	Орлогын зарцуулалт	5,3	
Нийгэм эдийн засгийн хувь нэмэр	Заавал тайлагнах нийгмийн зарцуулалт	6,1а	?
	Сайн дураар тайлагнах нийгмийн зарцуулалт	6,1б	
	Төрийн өмчит компаниудын нийгмийн зарцуулалт	6,2	??
	Эдийн засагт оруулж буй хувь нэмэр	6,3	
Үр дүн, үр нөлөө	Олон нийтийн хэлэлцүүлэг	7,1	
	Мэдээллийн хүртээмж	7,2	
	Зөвлөмжүүдийн биелэлт	7,3	
	Үр дүн, үр нөлөө	7,4	?

ГУРАВ. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ, АЖЛЫН ХЭСГЭЭС ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ

3.1. Үндэсний зөвлөлийн хуралдаан

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл 2016 онд 1 удаа хуралдсан байна. Үндэсний зөвлөл шаардлагатай шийдвэрүүдийг уг хурлаас гаргахын хамт Монгол Улсын Ерөнхий сайд Үндэсний зөвлөлийн даргын хувиар хуралдаанаа удирдаж, амжилттай зохион байгуулсан.

3.2. Ажлын хэсгийн хуралдаанууд

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн ээлжит хуралдаанууд 2016 онд 3 удаа зохиогдож, ирц 70 орчим хувьтай байсан.

Ажлын хэсгийн хуралдаанаас 10 гаруй шийдвэрүүдийг гаргаж, цаг үетэй холбогдсон шийдвэрүүд байсан, тэдгээр нь биелсэн байна.

3.3. ОИТБС (ЭБСИТБ)-ын тухай хуулийн төслийн тухай

Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хууль буюу Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг Монгол Улсын Их хурал 2015 оны 2 дугаар сард хэлэлцэж, уг төслийг хэлэлцэхээр шийдэж, Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийг байгуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхийг даалгасан. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, 2016 оны 1 дүгээр сард нэгдүгээр хэлэлцүүлэгт бэлтгэсэн хэдий ч, УИХ-ын сонгууль 6 дугаар сард болж, шинэчлэгдсэн тул шинэ Засгийн газар уг төслийг буцаан татсан байна.

3.4. ОУИТБС-ын санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ОУИТБС-ын хэрэгжүүлэх ажлын санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах үүднээс нэгтгэл тайлангийн санхүүжилтийг 2010 оноос эхлэн улсын төсвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд 2012 онд 201,1 сая төгрөг, 2013 онд 183 сая төгрөг, 2014 онд 220,1 сая төгрөг, 2015 онд 169 сая төгрөг зарцуулсан байна. 2016 онд 152,3 сая төгрөг зарцуулсан байна. Эдгээр төсвийн хөрөнгийг ихэнхи хэсгийг жил бүрийн нэгтгэл тайланг боловсруулахад зарцуулж байна.

Ажлын албыг Дэлхийн банкны итгэлийн сангийн санхүүжилтээр ажиллуулж байна. Гэвч санхүүжилт 2016 онд 8 сар саатсан бөгөөд 7 дугаар сард Сангийн яам, Дэлхийн банк төслийн шинэ гэрээг байгуулснаар, 2018 оны эцэс хүртэлх санхүүжилтыг 450 мян.ам.доллороор баталгаажуулаад байна.

3.5. Цахим тайлагналын 2 дугаар шатны ажлын тухай

Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр (300,000 евро) цахим тайлагналын 2 дугаар шатны ажлыг дуусгав. Гэхдээ Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газрын кадастрын сүлжээтэй байнгын холбоотой асуудлаа хийж чадаагүй хэвээр байна.

ДӨРӨВ. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН БАЙДАЛ

4.1. 2016 онд нийт 53 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 34 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлтийн хувь 65 байна.

4.2. Саатсан гол ажлууд орон нутгийн Дэд зөвлөлийг чадавхжуулахтай холбогдсон болон Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулах зэрэг байсан бөгөөд эдгээр ажлуудыг 2017 онд хэрэгжүүлэхээр хойшлуулж, төлөвлөгөөнд оруулсан байна.

ТАВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

ОУИТБС-ын үйл явцын талаархи Ажлын хэсгийн дүгнэлт

1.1. Монгол Улсын ОУИТБС-ын 10 удаагийн нэгдсэн тайланг гаргаж, тайлангаас тайланд хамрагдаж байгаа компанийн тоо олон жилийн дундаж хэмжээнд нэмэгдэж, аудитын нэгтгэлээр гарч байгаа зөрүү багасч байна.

1.2. Цаашид нэгтгэл тайлангийн ашиглалтыг сайжруулах, сургалт сурталчилгааны ажлыг улам идэвхжүүлэх хэрэгтэй байна.

- 1.3. Монгол Улсад ОУИТБС тогтвортой хэрэгжиж байгаа ч хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдал, хууль эрх зүйн тодорхойгүй байдлаас улбаалан томоохон шинэчлэл, өөрчлөлтийг хийх бололцоо дутмаг байгааг хүлээн зөвшөөрч байна.
- 1.4. МУ-ын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгдсөн зарим ажил, үйл ажиллагааг олон талт ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож буй уул уурхайн салбарын мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудад гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай байна.
- 1.5. Засгийн газрын байгууллагуудын оролцоо харьцангуй сайн байгаа ч, холбогдох байгууллагуудын дээд шатны удирдлагын оролцоо хангалтгүй байна. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүдийн ирц хангалтгүй, орлож ирэх үзэгдэл оршсоор байна. Хурлын тэмдэглэлийг дор бүр нь 7 хоногт цахим хуудас дээр тавьж, хурлын ирцийг нийтэд ил тод болгож, цахим хуудсаараа мэдээлж байна.
- 1.6. Компаниудын оролцоо идэвхгүй хэвээр байна. Ялангуяа, манлайлал болохуйц томоохон компаниудын удирдлагын оролцоо идэвхгүй байна. ОУИТБС-ын тайлангаа гаргахгүй байгаа компаниуд олон хэвээр байна.
- 1.7. Аймаг нийслэл, сум дүүргийн түвшинд ОУИТБС түүний шинэ бодлого, нэгтгэл тайлангийн мэдээллийг боловсруулж хүргэх, тэнд байгаа институцийг чадавхжуулах, эрхзүйн болон санхүүгийн орчныг баталгаажуулах, удирдамж чиглэлээр хангаж ажиллах шаардлага хэвээр байсаар байна.

ЗУРГАА. МОНГОЛ УЛСАД 2016 ОНД ОУИТБС-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ҮҮССЭН БЭРХШЭЭЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, АВСАН СУРГАМЖ

Дэлхийн банкны төслийн санхүүжилт 8 сар саатсан тул санхүүгийн эх үүсвэр доголдож, 20 гаруй үйл ажиллагааг хэрэгжүүлж чадаагүй байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг олох талаар хэд хэдэн байгууллагад хандсан хэдий ч амжилт олоогүй байна.

Иймд ОУИТБС-ын олон улсын баталгаажуулалтын дүнгээр доогуур үнэлгээ авсан үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг 2017 онд ахиулах, ОУИТБС-ын орон нутаг дахь хэрэгжилтийг хангах, дэд зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, ашиг хүртэгч эздийг ил тод болгох замын зургийг хэрэгжүүлэх, гэрээний ил тод байдлыг хангах талаар ажиллаж, 2017 оныг Монгол Улсад ОУИТБС-ын "ДЭД ЗӨВЛӨЛИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, АШИГ ХҮРТЭГЧ ЭЗДИЙГ ИЛ БОЛГОХ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ" жил болгох уриаг дэвшүүлсэн байна.

ДОЛОО. БАТАЛСАН ОГНОО 2016 ОНЫ 12 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР